

**ГАДААДЫН ИРГЭН, ХАРЬАТЫН ГАЗРЫН АГААРЫН ЗАМЫН БООМТ
ХАРИУЦСАН ГАЗРААС 2019 ОНЫ ДӨРӨВДҮГЭЭР САРД ХИЙЖ
ГҮЙЦЭТГЭСЭН ҮЙЛ АЖИЛЛАГААНЫ ТАЙЛАН**

2019 оны 04 дүгээр сарын 26

Улаанбаатар хот

Тус газар нь Гадаадын иргэний эрх зүйн байдлын тухай, Харьяатын тухай, Засгийн газрын 2010 оны 339 дүгээр тогтоолоор баталсан “Гадаадын иргэнийг Монгол Улсаас албадан гаргах болон Монгол Улсад дахин оруулахгүй байх хугацааг тогтоох журам”, 2018 оны 145, 146 дугаар тогтоолоор баталсан “Монгол Улсын виз олгох журам”, “Гадаадын иргэн Монгол Улсад оршин суух болон түүнийг бүртгэх журам” болон тэдгээрт нийцүүлэн гаргасан бусад эрх зүйн актуудыг удирдлага болгон иргэнд хөнгөн шуурхай, чирэгдэлгүй үйлчлэхэд анхаарч 2019 оны 3 дугаар сарын 26-аас 2019 оны 4 дүгээр сарын 25-ны өдрүүдэд дараах ажлыг хийж гүйцэтгэлээ.

Нэг. Үндсэн үйл ажиллагааны хүрээнд

1.1. Монгол Улсын виз, бүртгэлийн талаар:

Тайлант хугацаанд нийт 63 орны 299 гадаадын иргэнд зохих ангилал, зориулалтын визийг олгосон бөгөөд үүнээс визийн шилжүүлэг 9. Үүнд, нэг удаагийн орох 243, хоёр удаагийн орох 2, олон удаагийн орох 23, нэг удаагийн гарах-орох 15, хоёр удаагийн гарах-орох 5, олон удаагийн гарах-орох 2, дамжин өнгөрөх 0, түр ирэгчийн бүртгэл 32, хасалт 34, оршин суух зөвшөөрлийн хасалт 11 байна.

Үүнээс гадна тус газрын албан хаагчийн алдаатай бичсэн визийн хуудас 2 ширхэгийг хүчингүй болгож, Дипломат төлөөлөгчийн газраас алдаатай олгосон визийг шинээр 4 орны 12 гадаадын иргэнд олгосон ба оршин суух зөвшөөрлийг хүчингүй болгосон виз 3 орны 5 гадаадын иргэн байна.

1.2. Гадаадын иргэдэд тавих хяналт шалгалтын хүрээнд:

Тайлангийн хугацаанд Төв аймаг дахь ахлах мэргэжилтэн дараах ажлыг хийж гүйцэтгэсэн. Үүнд:

- Гадаадын иргэдийн оршин суух, хөдөлмөр эрхлэлтэнд дотоод сүлжээ ашиглан мэдээллийн сан бүрдүүлж Төв аймгийн ЗДТГ-ын Хууль эрх зүйн хэлтэс болон холбогдох байгууллагуудтай мэдээлэл солилцон ажиллаж байна. Төв аймгийн нутагт 2019 оны 4 дүгээр сарын 22-ны өдрийн байдлаар 16 улсын 294 гадаадын иргэн бүртгэлтэй байгаагаас үйл ажиллагаа тогтвортой явуулж байгаа 22 аж ахуйн нэгж дээр 160 гадаадын иргэн хөдөлмөр эрхлэгч статустай оршин сууж байна;

- Агаарын замын боомт хариуцсан газрын даргын 2019 оны 3 дугаар сарын 26-ны өдөр баталсан 10/04 дугаартай удирдамжийн даруу төлөвлөгөөт бус шалгалтыг мөн сарын 27-ны өдөр Төв аймгийн Сэргэлэн сумын нутагт дэвсгэрт хийв. Шалгалтаар Ган бөмбөлгийн үйлдвэрт хөдөлмөр эрхэлж байсан 1 орны 13 гадаадын иргэн биедээ бичиг баримтгүй явсан зөрчил илэрсэн тул Зөрчлийн тухай хуулийн 16.2.1.3-т зааснаар хүн тус бүрээр 1300000 төгрөгийн торгуулийн арга хэмжээ авч шийдвэрлэсэн. Мөн Сэргэлэн суманд үйл ажиллагаа явуулж байгаа 1 аж ахуйн нэгжид хөдөлмөр эрхэлж буй 1 орны 41 гадаадын иргэнийг шалгахад

зөрчил илрээгүй. Мөн Баянчандмань сумын нутагт үйл ажиллагаа явуулж байгаа 1 аж ахуйн нэгжид үйлдвэрлэлийн тоног төхөөрөмж угсрахаар орж ирсэн 1 орны 12 гадаадын иргэнийг шалгахад зөрчил илрээгүй болно. Тус удирдамжтай шалгалтанд нийт 3 аж ахуйн нэгж, 1 орны 66 гадаадын иргэн хамрагдлаа.

- Агаарын замын боомт хариуцсан газрын даргын 2019 оны 4 дүгээр сарын 4-ний өдөр баталсан 10/05 дугаартай удирдамжийн дагуу төлөвлөгөөт бус шалгалтыг мөн өдөр Төв аймгийн Баянцогт, Баянчандмань суманд хийв. Шалгалтанд 1 орны 7 гадаадын иргэн хамрагдсан ба зөрчилгүй үйл ажиллагаа явуулж байв.

- Агаарын замын боомт хариуцсан газрын даргын 2019 оны 4 дүгээр сарын 15-ны өдөр баталсан 10/06 дугаартай удирдамжийн дагуу төлөвлөгөөт шалгалтыг энэ сарын 23-ны өдөр Төв аймгийн Зуунмод, Алтанбулаг, Сэргэлэн сумдын нутагт үйл ажиллагаа явуулж байгаа хоолны газар, төмрийн үйлдвэр, цементийн үйлдвэр зэрэг газруудад хийсэн. Шалгалтанд 2 орны 52 гадаадын иргэн хамрагдсан бөгөөд бичиг баримтын зөрчилгүй байлаа.

Тайлангийн хугацаанд төлөвлөгөөт 1, төлөвлөгөөт бус 2, нийт 3 хяналт шалгалтан хийж 9 аж ахуйн нэгж, 2 орны 125 гадаадын иргэн хамрагдлаа. Үүнээс 1 орны 13 гадаадын иргэн биедээ бичиг баримтгүй явсан тул Зөрчлийн тухай хуулийн 16.2.1.3-т зааснаар хүн тус бүрээр 1300000 төгрөгийн торгуулийн арга хэмжээ авч шийдвэрлэсэн.

Төв аймаг дахь ахлах мэргэжилтэн 2019 оны 4 дүгээр сарын 21-ний өдөр аймгийн Иргэдийн Төлөөлөгчдийн Хуралд оролцож тус аймагт үйл ажиллагаа явуулж, оршин сууж байгаа гадаадын иргэдийн талаар сонголт мэдээлэл хийв.

Мөн "ISM" системээр давхардсан тоогоор 95 орны 11577 гадаадын иргэний мэдээллийг шүүж шалгасан ба илрүүлсэн зөрчлийн талаар хоногийн мэдээнд өдөр бүр тусгаж Хяналт-шинжилгээ, дотоод аудит, орон нутгийн хэлтэст хүргүүлэн ажиллаж байна.

Харин орон нутгийн нислэгээр зорчиж буй нийт 2 орны 2 гадаадын иргэний бичиг баримтад шалгалт хийхэд илэрсэн зөрчил байхгүй болно.

Олон улсын шилжилт хөдөлгөөний байгууллага /IOM/-аас өгсөн бичиг баримтын хуурмаглал шалгах төхөөрөмжийг ашиглан тайлант хугацаанд нийт 10 орны 59 гадаадын иргэний бичиг баримт, мэдээллийг шалгасан бөгөөд зөрчил илрээгүй байна.

1.3. Захиргааны арга хэмжээ авсан талаар:

Тайлангийн хугацаанд бүртгэлийн талаар тогтоосон журам зөрчсөн, визийн хугацаа хэтрүүлсэн, оршин суух журам зөрчсөн зэрэг үндэслэлээр 27 гадаадын иргэнд 3,120,000 төгрөг, 5 аж ахуйн нэгжид /хамрагдсан гадаадын иргэн 5/ 590,000 төгрөгийн торгуулийн арга хэмжээ авч, зөрчлийг арилган, зөвлөгөө мэдээлэл өгөв.

1.4. Монгол Улсаас албадан гаргасан гадаадын иргэний талаар:

Тайлант хугацаанд тус газраас албадан гаргасан гадаадын иргэн 0 байна. Харин төвөөс нийт 6 орны 13 гадаадын иргэнийг албадан гаргаж буй үйл ажиллагаанд тус газрын албан хаагчид оролцож, тодорхойлолт үйлдэв.

1.5. Хил нэвтрүүлэлгүй буцаасан иргэдийн талаар:

Тайлант хугацаанд Монгол Улсад орох визгүй нийт 3 орны 3 гадаадын иргэнийг Монгол Улсын хилээр оруулаагүй буцаасан байна. Харин гарах визгүй, аж ахуйн нэгжийн албан бичиггүй зэрэг үндэслэлээр нийт 6 орны 9 гадаадын иргэнийг Монгол Улсын хилээр гаргаагүй болно. Шүүх, прокурор, ШШГЕГ-ын хүсэлтийн дагуу Монгол Улсаас гарахыг түдгэлзүүлсэн гадаадын иргэн байхгүй байна.

1.6. Ярилцлагын тэмдэглэл болон баталгаа гаргуулан хил нэвтрүүлсэн талаар:

Монгол Улсад визгүй зорчигч гадаадын иргэн, хөдөлмөр эрхлэх магадлалтай 12 орны 70 гадаадын иргэнтэй ярилцлага хийж бичиг баримтыг хуулбарлан хилээр гарсан байдалд хяналт тавьж бүртгэл хөтөлсөн болно.

Иргэд харилцан зорчих нөхцлийн талаар байгуулсан Засгийн газар хоорондын хэлэлцээрийн дагуу Монгол Улсад зорчин ирж буй 6 орны 31 гадаадын иргэнийг угтан авч буй Монгол Улсын 5 иргэнээр баталгааны анкет бөглүүлэн хил нэвтрүүлж, уг гадаадын иргэний гарах хөдөлгөөнд хяналт тавин ажиллаж байна.

1.7. Иргэний харьяаллын талаар:

Хоёрдмол харьяалал үүсгэсэн 3 орны 3 иргэнээр өргөдөл-анкетыг бөглүүлэн холбогдох баримт бичгийг хуулбарлан авч Виз, зөвшөөрөл, харьяатын газарт хүргүүлсэн.

Хоёр. Дотоод ажлын хүрээнд

2.1. Тушаал, төлөвлөгөө, түүний хэрэгжилтийн талаар:

Тайлант хугацаанд тус газрын дарга нийт 1 тушаал /үндсэн үйл ажиллагаатай холбоотой 0, хүний нөөцтэй холбоотой 1/ батлан гаргаж биелэлтийг тооцон ажилласан ба 2019 оны дөрөвдүгээр сард хэрэгжүүлэн үндсэн арга хэмжээний төлөвлөгөөнд нийт 33 ажил хийж гүйцэтгэхээр тусгасан бөгөөд биелэлт 99 хувьтай гарлаа. Түүнчлэн тус газраас 2019 оны тавдугаар сард хэрэгжүүлэх үндсэн арга хэмжээний төлөвлөгөөг нэгтгэн мөн оны 4 дүгээр сарын 25-ны өдөр баталж үйл ажиллагаандаа мөрдөн ажиллаж байна.

Төвөөс өгсөн үүргийн дагуу дараах мэдээ, саналыг тогтоосон хугацаанд гаргаж холбогдох нэгжүүдэд хүргүүлээ:

- Тус газрын үндсэн үйл ажиллагааны талаарх хоногийн мэдээг гаргаж өдөр бүр, байгууллагын даргын батлан гаргасан албан даалгаврын биелэлтийг гаргаж 2019 оны 3 дугаар сарын 27-ны өдөр, ажлын байрны шинжилгээний анкетийг тус газрын 27 албан хаагчаар цахим хэлбэрээр бөглүүлж 4 дүгээр сарын 16-ны өдөр, өргөдөл, гомдлын мэдээ, инфографик мэдээг өмнөх оны мөн үетэй харьцуулан гаргаж 25-ны өдөр Хяналт-шинжилгээ, дотоод аудит, орон нутгийн хэлтэст;

- Агаарын замын боомт хариуцсан газрын албан хаагчдын хил нэвтэрсэн судалгааг /2019.01.01-2019.03.31/ гаргаж 2019 оны 4 дүгээр сарын 8-ны өдөр Захиргаа, удирдлагын газарт хүргүүлсэн.

Үүнээс гадна Олон улсын шилжилт хөдөлгөөний байгууллагад баримт бичгийн хуурмаглал илрүүлэх төхөөрөмж ашигласан талаарх 1 дүгээр улирлын тайланг гаргаж 2019 оны 4 дүгээр сарын 4-ний өдөр тус байгууллагад цахимаар хүргүүлсэн.

2.2. Архив, албан хэрэг хөтлөлт, өргөдөл, гомдлын талаар:

Тайлант хугацаанд 2018 онд үүссэн архивын нэгжийг хүлээн авах хуваарийн дагуу архивт хүлээн авч бүртгэлжүүлэх ажлыг хийлээ. Нийт 198 хадгаламжийн нэгж хүлээн авч, хадгалж байгаа бөгөөд архивын өрөөний чийг, дулааныг өдөр бүр хэмжиж бүртгэл хөтлөн ажиллаж байна. Хэмжилтээр дулаан 20-25С, чийг 20-23RH хооронд байна.

Бичиг хэрэгт 17 албан бичиг ирсэнийг бүртгэлжүүлэн холбогдох албан хаагчид хүлээлгэн өгч, хариутай 6 албан бичгийн шийдвэрлэлтэд хяналт тавин ажилласан ба 9 албан бичиг боловсруулж холбогдох байгууллагад хүргүүлэв.

Энэ сард иргэн, аж ахуйн нэгж, байгууллагаас ирүүлсэн өргөдөл, гомдол байхгүй болно. Харин тус газрын 1 албан хаагчаас ирсэн өргөдлийг Захиргаа, удирдлагын газарт 2019 оны 4 дүгээр сарын 16-ны өдөр хүргүүлсэн.

Цаасан суурьтай баримтыг цахим хэлбэрт шилжүүлэх ажлын хүрээнд тус газарт ирсэн, явсан албан бичиг, тус газрын даргын батлан гаргасан тушаал, тус газрын энэ сарын төлөвлөгөө, түүний биелэлт, тайланг сканердаж цахим хэлбэрт шилжүүлсэн болно.

2.3. Хүний нөөц, сургалтын талаар:

Байгууллагын даргын 2018 оны Б/347 дугаар тушаалын дагуу тус газрын батлагдсан орон тоо 29 бөгөөд одоо ажиллаж байгаа 28 албан хаагч, ээлжийн амралттай 0, хүүхэд асрах чөлөөтэй 2 албан хаагч байна. Байгууллагын даргын 2019 оны Б/103 дугаар тушаалын дагуу тус газрын 1 мэргэжилтэний бичгээр гаргасан хүсэлтийн дагуу тухайн албан хаагчийг 2019 оны 4 дүгээр сарын 10-ны өдрөөс төрийн албанаас чөлөөлсөн тул ажил хүлээлцүүлж, холбогдох тооцоог хийлээ.

Тайлант хугацаанд байгууллагын даргын 2019 оны Б/99 дүгээр тушаалын дагуу нэг удаагийн гарах-орох визийн хүчинтэй хугацааг буруу бичиж олгосон тус газрын 1 албан хаагчид сануулах сахилгын шийтгэл ногдуулсан. Мөн Зөрчлийн тухай хуулийн дагуу торгох шийтгэл оногдуулсан зөрчлийг материалыг Хяналт шалгалтын газраас шалгаж зөрчил гаргасан 9 албан хаагчийн сахилгын талонд 2019 оны 3 дугаар сарын 27-ны өдөр арга хэмжээ авсан болно. Түүнчлэн олон нийтийн арга хэмжээ буюу албанаас зохион байгуулсан сургалтыг тасалсан 1 хяналтын улсын байцаагчийн сахилгын талонд 2019 оны 4 дүгээр сарын 11-ний өдөр арга хэмжээ авсан болно.

Төрийн албаны зөвлөлийн цахим програмд тус газрын нийт албан хаагчийн 3 дугаар сард авсан нэмэгдлийн талаарх мэдээллийг оруулсан болно.

Төв болон тус газраас зохион байгуулсан дараах сургалтуудад албан хаагчид хамрагдав. Үүнд:

1. Төвөөс зохион байгуулсан дараах сургалтуудад албан хаагчдыг хамруулав:

– Байгууллагын даргын 2019 оны Б/95 дугаар тушаалын дагуу тус газрын захиргааны ахлах мэргэжилтэн 2019 оны 10-12-ны өдрүүдэд архив, албан хэрэг хөтлөлт, төрийн байгууллагын ажлын зохион байгуулалтын улсын үзлэгт бэлтгэх зорилгоор зохион байгуулсан сургалтад хамрагдав;

– 2019 оны 4 дүгээр сарын 12-ны өдрийн мэдээллийн цагаар зохион байгуулсан сургалтад тус газрын 18 албан хаагч хамрагдсан. Сургалтаар Монголын илтгэгчдийн холбооны ерөнхийлөгч Ц.Азбаяр “Төрийн албан хаагчийн өрсөлдөх чадвар, хандлага” сэдвийн хүрээнд мэдээлэл хүргэв;

– 2019 оны 4 дүгээр сарын 19-ний өдөр онлайн хурлаар зохион байгуулсан сургалтад тус газрын нийт 13 албан хаагч хамрагдаж Хан-Уул дүүргийн Улаан загалмайн хорооны арга зүйч Б.Оюунчимэг осол, гэмтэлд өртсөн хүнд үзүүлэх эмнэлгийн анхны тусгамжийн талаар анхан шатны мэдлэг олгов.

2. Тус газраас тайлант хугацаанд нийт 3 сургалт зохион байгуулж ажиллав:

– Гэмтэл согог судлалын үндэсний төвтэй хамтран 2019 оны 4 дүгээр сарын 9-ний өдөр “Өвдөгний үеийн эмгэг өөрчлөлт, түүнээс урьдчилан сэргийлэх” сэдэвт сургалт тус газрын 14 албан хаагчдад зохион байгуулав. Сургалтаар тус төвийн Үений тасгийн эрхлэгч Ө.Өлзийбаатар Монгол Улсад түгээмэл тохиолддог өвдөгний үеийн өвчин үүсдэг шалтгаан, түүнээс урьдчилан сэргийлэх аргын талаар албан хаагчдад мэдээлэл өгөв;

– Иргэний агаарын тээвэр дэх Цагдаагийн хэлтэстэй хамтран 2019 оны 4 дүгээр сарын 24-ний өдөр сургалт зохион байгуулж эрүүгийн тасгийн эдийн засгийн эрүүгийн мөрдөгч, ахлах дэслэгч М.Батцэнгэл “Эдийн засгийн гэмт хэргийн өнөөгийн нөхцөл байдал, анхаарах асуудал” сэдвийн хүрээнд мансууруулах эм, сэтгэцэд нөлөөт бодисын хууль бус эргэлт, хилийн боомтоор нэвтрүүлэхийг завдсан оролдлогууд, арга барил, илрүүлсэн тохиодолд авах арга хэмжээний талаар мэдээлэл хүргэж, тус газрын 15 албан хаагч хамрагдав.

– Иргэний агаарын тээвэр дэх Цагдаагийн хэлтэстэй хамтран 2019 оны 4 дүгээр сарын 24-ний өдөр тус газрын 2 жолоочид сургалт зохион байгуулсан. Сургалтаар Иргэний агаарын тээвэр дэх Цагдаагийн хэлтсийн ахлах зохицуулагч, хошууч Ц.Өнөрбат Замын хөдөлгөөний дүрэм, Зөрчлийн тухай хуулийн талаар мэдээлэл өгөв. Зохион байгуулсан сургалтуудад төсвөөс зардал гараагүй болно.

2.4. Санхүү, хангалт үйлчилгээний ажлын талаар:

Тайлант хугацаанд батлагдсан төсвийг зохих зардлын дагуу зарцуулан өр, авлагагүй ажилласан ба холбогдох мэдээллийг шилэн дансанд байршуулсан.

Батлагдсан төсвийг зохих зардлын дагуу зарцуулан өр, авлагагүй ажилласан. Батлагдсан төсөв болох өссөн дүнгээр 196,506,900 төгрөгийн санхүүжилт орсноор цалин хөлсөнд 118,595,780 төгрөг, ажил олгогчоос нийгмийн даатгалын шимтгэл 12,953,524 төгрөг, Хан-Уул дүүрэгт цалин хөлснөөс суутгасан ашгийн татварт 7,103,465 төгрөг зарцуулж өглөг авлага үүсгээгүй ажиллалаа.

Төсвийн гүйцэтгэлийн мэдээг 2019.04.02-ны дотор гарган Хан-Уул дүүргийн төрийн сангаар баталгаажуулан Гадаадын иргэн, харьяатын газрын Санхүү, хангалт, үйлчилгээний газарт хүргүүлсэн. Мэдээгээр 147,225,200 төгрөгийн урсгал санхүүжилт орсоноос нийт зарлага 123,125,870 төгрөгийн ажил үйлчилгээ явуулсан.

Нийгмийн даатгалын шитгэлийн тайланг гарган 2019.04.05-ны дотор Нийгмийн даатгалын хэлтэст хүргүүлэн өссөн дүнгээр 23,005,681 төгрөгөөр тооцоо нийлэв.

Албан хаагчдад шийтгэлийн хуудас 0, визийн хуудас 300 ширхэгийг шаардах хуудасны дагуу олгосон. Түүнчлэн авто машины ашиглалт болон шатах тослох материалын тооцоог жолооч дэвтэрт бичилтийг хийн бүртгэл хөтлөв.

Албан хэрэгцээнд ашиглаж байгаа суурин утас болон интернетийн төлбөрт өссөн дүнгээр 445,165 төгрөг, байрны түрээс 12,343,000 төгрөг харилцагч байгууллагын нэхэмжлэхийн дагуу холбогдох данс руу шилжүүлсэн болно.

Хүү торгууль өссөн дүнгээр 15,600,000 төгрөгийг Төв аймгийн төрийн санд, визийн тэмдэгтийн хураамж өссөн дүнгээр 87,784,050 төгрөг, визийн хуудас 6,534,090 төгрөгөөр тайлан нэгтгэн хяналтын улсын байцаагч нартай тооцоо нийлэн Гадаадын иргэн, харьяатын газрын Санхүүгийн хэлтэст хүргүүлсэн.

Бараа материалд өссөн дүнгээр 5,926,170 төгрөгийн худалдан авалтыг хийж шаардах хуудасны дагуу албан хаагчдад өгсөн байна. Бараа материалын болон шатахууны тайланг гаргахдаа Нягтлан бодох бүртгэлийн хуулийн дагуу анхан шатны баримтыг бүрдүүлэн гаргасан ба хянуулж баталгаажуулсан.

Түлш шатах тослох материалд өссөн дүнгээр 3,916,500 төгрөгийн зарцуулалт гаргаж тайлагнасан байна.

Тус газрын 28 албан хаагч, хүүхэд асрах чөлөөтэй 2 албан хаагчийн нийгмийн даатгал, эрүүл мэндийн даатгалын дэвтэрт холбогдох бичилтийг хийж Хан-Уул дүүргийн Нийгмийн даатгалын хэлтсээр баталгаажуулав.

Өдөр бүрийн визийн тайланг хүлээн авч санхүүгийн баримттай тулгалт хийн албан хаагчидтай тооцоо нийлснээр ахлах нягтлан бодогчид хянуулж ажилласан ба бэлэн мөнгө, бусад хангамжийн материал, нормын хувцас, бичиг хэрэг, түлш шатах материалын 2019 оны 1-р улирлын тайланг гаргасан.

Үйлчилгээнд явж буй Приус-20, Соната-7 автомашины цэвэрлэгээ үйлчилгээг тогтмол хийн хэвийн ажиллагааг ханган ажиллаж, батлагдсан маршрутын дагуу албан хаагчдыг тээвэрлэж, замын хуудсыг бөглөн санхүүтэй тооцоо нийлж ажиллав. Мөн тус 2 автомашинуудын улирлын ээлжит тос тосолгоог “Авто плаза” засварын газарт хийлгэлээ.

2.5. Мэдээллийн технологийн чиглэлээр:

Тайлант хугацаанд дотоод сүлжээний 7, техник хэрэгслийн 5, нийт 12 дуудлага хүлээн авч засварлаж ажиллалаа.

Иргэний нисэхийн ерөнхий газрын цахилгаан тасрахтай холбогдуулан 2019 оны 4 дүгээр сарын 16-ны өдөр “Чингис Хаан” олон улсын нисэх буудлын ирэгч, явагчийн танхимд байрлах ажлын өрөөний 2 компьютерт “ISM” програм ажиллагаагүй болсон нөхцөлд ашиглах виз хэвлэх програмыг /төвөөс хөгжүүлсэн/ шинээр дахин суулгасан. Төв аймаг дахь ахлах мэргэжилтэний өрөөний компьютерийг форматлан, дотоод сүлжээ болон хэрэглээний бүх програм хангамжийг суулгав.

Тайлант хугацаанд нийт 3 удаа цахим хурлын төхөөрөмжийг холбон, Хилийн 0218-р ангиас сүлжээг залгуулан хурлыг дамжуулсан болно.

Тус газрын түүхэн ном гаргахтай холбогдуулан виз, зөвшөөрлийн ахлах мэргэжилтэнтэй хэвлэлийн эх болон номонд байршуулах мэдээ мэдээлэл, фото зургийн санд хамтран ажиллаж байна.

Тайлант хугацаанд сүлжээ болон техник хэрэгслийн өдөр тутмын хэвийн найдвартай ажиллагааг хангаж ажилласан болно.

Гурав. Олон нийттэй харилцах чиглэлээр

Тус газрын мэдээллийн самбарт 2019 оны 3 дугаар сард хэрэгжүүлэх үндсэн арга хэмжээний төлөвлөгөөний биелэлт, хийж гүйцэтгэсэн үйл ажиллагааны тайлан, өргөдөл, гомдлын мэдээ, 4 дүгээр сард хэрэгжүүлэх үндсэн арга хэмжээний төлөвлөгөөг байршуулж олон нийтийг мэдээллээр хангаж ажиллалаа.

Дөрөв. Бусад

Тус газрын ээлжийн албан хаагчдын цугларалтыг 2019 оны 4 дүгээр сарын 24-ний өдөр зохион байгуулж албанд гарч буй хүндрэлийн талаар хэлэлцэж, тус газрын даргаас үүрэг чиглэл өгөв.